

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-18

<i>1.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	6-7
<i>2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	7-15
<i>3.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	16-18
<i>4.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	18
<i>5.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /эцсийн хэлэлцүүлэг/</i>	18

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
07 дугаар сарын 06-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Булгантуяа, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, С.Одонтуяа, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Нэг. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга С.Цэрэнбаяр, мөн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Захиргаа, хууль, эрх зүйн газрын ерөнхий санхүүч П.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6

Бүгд: 12

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газраас гаргасан эрх зүйн дүгнэлтийг тус газрын дарга Н.Мягмар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Өнөрболор, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан, Төсөлд ““1.5 мегаваттаас” гэснийг “15 мегаваттаас” /хот, хөдөөгийн ялгамжтай/ гэж өөрчилж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 10
Бүгд: 12
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан, Төслийн “дулааны болон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж буй түүхий эдийн стандартыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн зөрүүг тэглэх ажлыг эрчимжүүлэх” гэснийг “дулааны болон цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж буй түүхий эдийн стандартыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 49 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
13 цаг 08 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Лхагвын Мөнхбаатар гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Баделхан гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Чойжилсүрэн гишүүн, Мөнхбаатар гишүүн нар хүрэлцэн ирснээр өнөөдөр, Амартүвшин гишүүн хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Ингээд Төсвийн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Тогтоолд өөрчлөлт орох оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл Төсвийн байнгын хороо боловсруулсан. 2-т ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 23-ны 6 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, 3 дугаарт Хууль эцэслэсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төсвийн байнгын хороо боловсруулсан анхны хэлэлцүүлэг, 4 дүгээрт Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 32 гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн эцсийн хэлэлцүүлэг байгаа. 5 дугаарт Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Засгийн газар нэн яаралтай горимоор 6 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг гэсэн энэ 5 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудал. Таны карт орсон уу? Өнөрболор гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал хэлэх байна. Өнөрболор гишүүний микрофоныг өгье.

Д.Өнөрболор: ААНОАТ-ын хуулийг эцэслэн хэлэлцүүлэх энэ юунд холбоотойгоор би энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүгдэд бас юу яая гаргая гэж бодож байна. Тэгээд энэ саналын томъёолол бол хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн нэгийн 1,5 мвт-аас гэснийг 15мвт-аас гэж өөрчлөх ийм зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гаргаж байна. Тэгээд энийг санал хураалгаж дэмжүүлж өг өгөөч гэж хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр хуулиа хэлэлцэх үедээ тэгвэл ярилцаад явъя. Хэлэлцэх асуудал дээр тэгвэл саналтай гишүүн алга байна. Бүгдээрээ хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг

1 дүгээрт Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Төрийн аудитын байгууллагаас 2023 оны 6 сарын 29-ний өдөр Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай саналаа ирүүлсэн. Үүний дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын ерөнхий аудитор, түүний орлогчийг тус тогтоолд хамааруулахаар Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их

Хурлын тогтоолын төслийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Та бүхэн тогтоолын төслийг тараасан байгаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 63 дугаар тогтоолын үндэслэл хэсгийн Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг мөн тогтоолын 1 дэх заалтын Дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга, дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга гэснийг тус тус хассугай. Энэ тогтоолыг 23 оны ... дугаар сарын өдрөөс гэх үү, өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбоотой зарчмын талаар санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Дэмжье, тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад дахиад 2 дахь санал байгаа. Энэ тогтоолыг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн 2 дахь заалт дээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Хүрэлбаатар сайд горимын санал гаргачих уу та? Хүрэлбаатар сайдад микрофон өгье.

Ч.Хүрэлбаатар: Үгүй ээ уг нь сая дэмжиж санал өгөөд энэ хурууны хээ дээр л болсонгүй.

Г.Тэмүүлэн: Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Хүрэлбаатар сайдын саналаар. Санал хураалт. Төхөөрөмж ажиллагаагүй. Бас дахиад алдаа гарч

байна, Өнөрболор гишүүнийх байна. Пүрэвдорж. Өнөрболор гишүүн санал гаргая.

Д.Өнөрболор: Миний төхөөрөмж ажилласангүй даргаа, энэ саналыг хүчингүй болгоод дахиад санал хураалгаж болох уу.

Г.Тэмүүлэн: Тэгье. Өнөрболор гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 58.3 хувиар дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн тул түрүүн түрүүний тогтоол, тогтоолд хэрэгжих хугацааг 7 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн заалт дээр дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 63,6 хувиар дэмжигдлээ. Ингээд тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Батжаргал гишүүнээр танилцуулахаар томилж байна. Батжаргал гишүүн танилцуулна. Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

13.13 цаг

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

2 дугаар асуудалдаа оръё. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулж ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулж ирэхийг урьж байна. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг танилцуулж байх хооронд Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс ирүүлсэн дүгнэлтийг танилцуулах ёстой. Холбогдох даргыг нь газрын даргыг нь дуудаарай. Мягмар дарга байгаа юм байна. Улсын Их Хурлын

Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Мягмар.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Зоригийн Мөнх-Оргил ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандоржийн Мөнхжаргал ЭХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Басбаярын Болор-Эрдэнэ Эрчим хүчний зохицуулах хорооны ажлын албаны дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор Төсвийн байнгын хорооны хуралдааны 7 сарын 3-ны өдрийн хуралдаанаар энэ асуудалд эрх зүйн дүгнэлт гаргуулах санал гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх нь дэмжсэн байгаа. Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс 2023 оны 7 сарын 5-ны өдөр эрх зүйн дүгнэлтийг ирүүлсэн байна. Эрх зүйн дүгнэлтийг танилцуулах ёстой. Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Мягмар дарга таныг микрофонд урьж байна. 1 номер, ажлын хэсгийн 1 номерын микрофон.

Н.Мягмар: *Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,*

Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 7 сарын 3-ны өдрийн 11/6085 дугаартай эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай албан бичгийн дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс болон Хууль, эрх зүйн газраас гаргасан дүгнэлтийг танилцуулъя. Эрх зүйн дүгнэлт гаргах үндэслэл. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Монгол

Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, төслийн зохицуулалтын хэрэгжих боломжийн талаар Төсвийн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдөр ирүүлсэн эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай албан бичиг, Төсвийн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны тэмдэглэл болон зарчмын зөрүүтэй саналын томъёолол зэргийг хянан үзээд дараах дүгнэлтийг гаргаж байна.

Эрх зүйн дүгнэлт гаргахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.23 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйл, ХЗБХ-ны 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан хууль зүйн дүгнэлт гаргах журамд заасныг баримталлаа. Хууль зүйн дүгнэлтийн хүрээ, хязгаар, эрх зүйн дүгнэлт гаргахад ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль бусад хуультай нийцэж байгаа эсэх, хэрэгжих боломжийн талаар эрх зүйн дүгнэлт хийлгэх тухай Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийг үндэслэлээ.

1.Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд 22.5.14 Цахилгаан эрчим хүчний 5мвт-аас дээш хүчин чадалтай эсхүл дулааны эрчим хүчний 1,5мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг 90 хувь хөнгөлнө гэсэн агуулга бүхий заалтыг ААНОАТ-ын тухай хуульд шинээр нэмж оруулахаар тусгажээ.

Монгол Улсын Засгийн газар Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн нэг дэх

хэсэгт Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд эрхийн хүрээ энэхүү эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтооно гэж. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-д Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлого болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газрын санаачилгаар Үндсэн хууль бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль санаачлах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна гэж заасны дагуу хууль санаачлах эрхээ эдлэн, өөрт олгогдсон эрхийн хүрээ хязгаарт багтаан ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан ААНОАТ-ын тухай хуулийн зорилт нь ААН-ийн орлогын албан татвар ноогдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд мөн хуулийн 22 дугаар зүйлээр хуульд заасан нөхцөлийг хангасан албан татвар төлөгчид хуульд заасны дагуу ноогдуулсан албан татварыг хөнгөлөх хувь хэмжээ, хөнгөлөлт ноогдуулах орлогын төрөл, хөнгөлөлт ноогдуулах журмыг зааж өгсөн байна. Дээр дурдсан хууль зүйн үндэслэлээр хууль санаачлагчаас албан татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлаар боловсруулсан тус хуулийн төслийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцсэн гэж үзэж байна.

2.Төслийн зохицуулалтын хэрэгжих боломжийн талаар. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар цахилгаан эрчим хүчний 5мвт-аас дээш хүчин

чадалтай эсхүл дулааны эрчим хүчний 1,5мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах төнөг төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэгч дотоодын компаниуд хуулийн үйлчлэлд хамаарахаар байна. ААН компаниуд нь аж ахуйн үйл ажиллагаа явуулснаас олгох орлогоо татварын хууль тогтоомжийн дагуу тайлагнаж, хуулийн дагуу ноогдох татвараа төлөх, хөнгөлөлт чөлөөлт эдлэх эрх зүйн зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байна. Иймд ААН-ийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хэрэгжих бүрэн боломжтой байна.

Дүгнэлт 1. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

2.ААНОАТ-ын тухай хуулийн нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь батлагдсанаар хэрэгжих бүрэн боломжтой байна. Хууль зүйн дүгнэлтийг танилцуулж дууслаа.

Г.Тэмүүлэн: Мягмар даргад баярлалаа. Эрх зүйн дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Өнөрболор гишүүнээр тасаллаа. Өнөрболор гишүүн асуулт асууя.

Д.Өнөрболор: Энэ ард иргэдийнхээ эсрэг яваад байгаа энэ бодлогыг ганцаараа би ингээд дуугараад байгаа нь бас их тийм сонин л асуудал болж хувирч байна л даа. Ер нь энэ баяр наадмын уур амьсгалтай ард иргэдийн бас нэг энэ анхаарал сарничихсан байгаа яг ийм үеэр ард иргэдийн эрхийг зөрчсөн хуулийг өнөөдөр ингээд хүч түрж батлуулах нь. Би бол хэлээд байгаа. Энэ хуулиар Шинэ сэргэлтийн бодлогын том бодлоготой зэрэгцээд Улаанбаатар хотод тийм ээ, түүхий нүүрс, утаа үйлдвэрлэх ийм бодлого орж ирээд байгааг л би эсэргүүцээд байгаа юм. Тэрнээс үндсэндээ бүхэлд нь бол биш.

Тэгээд энэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх энэ бодлогын зорилтыг эхнээсээ дэмжиж байгаагаа бол олон удаа хэлээд байгаа. Гэхдээ энэ нүүрсээр нийслэлийн иргэдийг хордуулах хууль Үндсэн хууль бусад хуульд бол нийцсэн эсэх үүнийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар бол би нэг дэх өдөр дүгнэлт гаргаад өгөөч гээд Байнгын хороогоор хүсэлт гаргасан юм. Тэгээд энэ гэтэл бол үндсэндээ ямар ч зөрчилгүй, Үндсэн хууль бусад хуульд нийцсэн ямар ч асуудалгүй гэж дүгнэжээ.

Тэгээд энэ дүгнэлтийг гаргасан хүмүүс энэ дарга нарын даалгавар, лоббигоор иргэдийнхээ эсрэг улайм цайм үгүй гэж хэлж байгаад би үнэхээр харамсаж байна. Монголын төр төрийн албанд дарга засагладаггүй хууль засагладаг байх ёстой. Энэ дүгнэлт гаргасан албан хаагчид улс орноо, ард иргэдийнхээ төлөө өргөсөн тангаргаасаа бол буцаж байна гэж бол харж байна. Энэ дүгнэлтээс харахад хууль санаачлах, өргөн барихтай холбоотой зөвхөн процессыг нь л аваад үзчихжээ. Гэтэл цаана нь маш их иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ эрх бол зөрчигдсөөр, Үндсэн хууль бусад хуульд нийцсэн гэж ингэж дүгнэж болдог юм уу? Энэ хуулийг зүтгүүлж байгаа Тэмүүлэн дарга, Чойжилсүрэн дарга нар бол иргэдийн эрүүл мэндийн эсрэг энэ үйлдэл нь энэ дүгнэлтэд оролцсон. Би бол маш өрөвдөлтэй байгаа нь төрийн албан хаагч нар Баянмөнх, Энхбат, Өлзийсайхан дарга нар дээр л энэ хариуцлага нь бууж үлдэх байх даа л гэж одоо харамсаж байгаа юм.

Тэгээд төрийн нэр хүнд энэ, өнөөдөр иргэдийн төрд итгэх итгэл ийм төрлийн үйл ажиллагаанаас болж л хохирч байгаа шүү дээ. Энийг хэн хариуцах юм бэ? Одоогийн Ерөнхийлөгч 2018 онд Ерөнхий сайд байхдаа түүхий нүүрсний хэрэглээг халсан түүхэн шийдвэр гаргасан. Энэ шийдвэр тавхан жилийн настай байгаад би үнэхээр харамсаж байна. Энэ ойн дээрээ яг адилхан нэг намын том зорилт энэ

намын тэ сайд Чойжилсүрэн таны үед энэ ард иргэдийнхээ эрүүл мэндийг хохироон, хохироон түүхий нүүрс рүү ухарч байгаад би бүүр илүү л харамсаад байгаа юм.

Тэгээд өнөөдөр агаарын бохирдлоос бол жилд дунджаар 4 мянга гаруй хүн нас барж байгаа. Харвалт, зүрх судасны өвчин, уушгины хавдар, амьсгалын замын өвчний гол шалтгаан нь болж байгаа юм. 100 мянган хүн тутамд ноогдох энэ агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын тоо дэлхийн дунджаас 1,4 дахин их байгаа. Тэгээд бодит байдал ийм ноцтой хэмжээнд байхад түүхий нүүрсний хэрэглээг зөвшөөрөөд л, тэгээд манай Байнгын хорооны гишүүд бол яах вэ одоо ингээд та нар зөвшөөрөөд ингээд явж болно. Гэхдээ хоёрхон сарын дараа ард иргэд та нараас хариуцлага хүлээх нөхцөл байдал үүсэх байх шүү.

Би энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргасан юм. 1,5-ыг 15мвт болгоё гээд. 15мвт нь бол өнөөдөр үндсэндээ бүрэн шаталттай 99,99 хувийн утаа ингээд шүүх ингээд чадвартай ийм дэд өртөө байгаа. 1,5 бол энэ бол зөвхөн түүхий нүүрсээр л ажиллах ийм боломжтой яндангууд л угсарна гэсэн үг. Тэгээд энэ дээр та нар ингээд ийм шийдвэр ингээд гараад явах юм бол ард иргэдийнхээ эсрэг зөрчсөн, ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлын эсрэг тэр байтугай улс орны тусгаар тогтнолыг хүртэл ингээд эрсдэлд аваачсан ийм нөхцөл байдал руу орж байгаа гэдгийг гишүүд маань та бүгд ойлгож байгаа биз дээ. Тийм учраас миний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг та бүгдийг дэмжиж өгөхийг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн эрх зүйн дүгнэлттэй холбогдуулаад тайлбар хэллээ. Мягмар, асуулт Мягмар даргаас. Мягмар дарга та тэгвэл эрх зүйн дүгнэлттэй холбогдуулаад нэмэлт тайлбар хэлэх үү.

Н.Мягмар: Өнөрболор гишүүний асуултад хариулт. Эрх зүйн дүгнэлт гаргах асуудал бол хуулиар зохицуулагддаг. Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд тодорхой зааж өгсөн. Мөн эрх зүйн дүгнэлт гаргах тухай Улсын Их Хурлын ХЗБХ-ны журамтай. Энэ журам болон хуулийн зохицуулалтаар эрх зүйн дүгнэлт гаргах хүрээ хязгаарыг бол зааж өгсөн. Эндээс бол хууль зүйн, Эдийн засгийн байнгын хорооноос ирсэн албан бичгээр бол хууль зүйн төсөл нь хуулийн төсөл нь бол Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, 2-т нь төслийн зохицуулалтыг хэрэгжих боломжийн талаар дүгнэлт гаргаж өг гэдэг ийм хүрээ хязгаарыг тодорхой зааж ирүүлсэн. Энэ дагуу гаргасан дүгнэлтээ би сая танилцууллаа.

Энэ дээр заахдаа бол хуулийн төсөл маань бол хоёрхон, 2 зүйлтэй. Эхний зүйл маань бол цахилгаан эрчим хүчний 5мвт-аас дээш чадалтай эсвэл дулааны эрчим хүчний 1,5мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг 90 хувь хөнгөлнө гэсэн 1 дүгээр заалт байж байгаа. Энэ заалтыг авч үзэхлээр энэ заалт дээр нүүрс гэдэг юм уу эсвэл өөр технологийн шинжтэй агаарын бохирдолтой холбоотой зүйл бол энд тусгагдаагүй. Тэгэхээр энэ заалтын агуулга нь Үндсэн хуулиараа хууль санаачлах эрхийн хүрээ хязгаартаа байна уу, 2 дугаарт хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудал энэ хуулийг зохицуулах харилцаанд хамаарч байна уу гэдэг энэ агуулгаараа авч үзэх юм бол саяын дүгнэлтээр бол Үндсэн хууль болон ААНОАТ-ын тухай хууль хөнгөлөлтийн хувь хэмжээ тогтоож байгаа холбогдох хэсэгтэй энэ маань заалт болж нэмэлтээр орж ирж байна. Энэ нь бол Үндсэн хуулиар хууль санаачлах эрхийн хүрээ хязгаар болон хуулийнхаа зохицуулж байгаа харилцаатайгаа нийцэж байна гэж үндсэндээ дүгнэсэн.

Өнөрболор гишүүний саяын ярьж байгаа нүүрсний болон агаарын бохирдолтой холбоотой энэ асуудлыг бол хууль санаачлагч буюу Засгийн газар түүний бүтцийн байгууллага болох ЭХЯ-наас бол хариулах байх.

Г.Тэмүүлэн: Юун дээр ЭХЯ хэн хариулах вэ? Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Олон дахин ярьсан учраас товчхон ярья даа. Өнөрболор гишүүнээ энэ танд би олон дахин юу хүсэлт тавьж, учирлаж тайлбарласан. Танаас 1 бүтэн өдөр, 2 өдөр цаг гаргачхаач, нөхцөл байдлыг бодит байдал дээр нь газар дээр нь яваад үзүүлье. Таны энэ болгоомжлоод байгаа зүйл чинь таны ярьж байгаагийн чинь эсрэг байгаа юм биш биз дээ. Бид нар танд бас нотлон харуулах бололцоо олгооч гэж хүссэн. Агуулгын хувьд. Олон дахин яриад байгаа нь энэ бид нар бүтэшигүй эсвэл хэт том зорилт тавиад 2030 онд 35 онд юу тавих зорилтууд байна дунд хугацаандаа. Түүнээс гадна наана нь 2020 юу 23, 24, 25 онууддаа өөрийнхөө боломжоор утаа бууруулах ажлыг шийдээд явж байвал яасан юм бэ л гэсэн ийм саналыг л танд тавих гээд байгаа юм. Утаа та нэмэгдүүлээ гэж яриад байгаа. Одоо би ондоо үзэл бодолтой байгаа таны үзэл бодлыг хүндэлж байна.

Гэхдээ таны бодож байгаагаас бодит байдал дээр эсрэг байх юм биш биз дээ. Энийг танд нотлон харуулах бололцоо олгооч л гэж хүсэж байгаа юм. Оndoо зүйл байхгүй, таны үзэл бодлыг хүндлэлгүй яах вэ.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн нэмж тодруулъя.

Д.Өнөрболор: Ер нь юу гэдэг юм энэ чуулган дээр бол бас ингээд нээлттэй бас мэтгэлцэх нь бол би зүйтэй гэж бодож байгаа юм. Гэхдээ дэгээр бол тийм ээ зөвхөн анхны хэлэлцүүлгээр хязгаарласан байгаа нь бол маш учир дутагдалтай. Ер нь энийг бол бид нар

харах ёстой юм байна. Би энэ Чойжилсүрэн сайдын хэлээд байгаа асуудлыг та ингээд бараг л энэ мэргэжлийн улсуудаас бол Эрчим хүчний сайд гэхээсээ ичих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл мэргэжлийн улсууд таны энэ ярьж байгаа энэ зүйлийг бол танд бол та бол эрчим хүчний талаар ямар ч мэдлэггүй байна гэж дүгнэхэд хүргэж байгаа шүү. Тэгэхээр та бас энэ дээрээ болгоомжтой буруу ярьж болно, лоббидож болно, тийм ээ гэхдээ бас ийм улаан цайм бас байж болохгүй гэдэг асуудлыг би бас танд хэлье.

Та бүхэн мэдэж байгаа 2018 оны 62 дугаар тогтоолоор Засгийн газрын шийдвэрээр түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон байж байгаа. Үүний эсрэг бол манай энэ төрийн албан хаагч нар нэн ялангуяа Тамгын газрынхан бол үндсэндээ бол энэ ард иргэдийнхээ төлөө өргөсөн тангаргаасаа бол буцлаа, няцлаа гэдгийг бол би сая хэлсэн.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж нэг 1 минут тодруулга хийе.

Д.Өнөрболор: Тийм бид нар бас мэдээж дэг байх нь бол чухал л даа. Гэхдээ Тэмүүлэн гишүүнээ та бас орчин үеийн залуу хүн байна тийм ээ бас асуудалд бол бас нээлттэй хандах нь бол бас илүү эвтэйхэн гэж би бодож байна. Нөгөөтээгүүр гээд тэгэхээр үндсэндээ бол энэ миний энэ зарчмын зөрүүтэй саналыг би бас гишүүдийг дэмжиж өгөөч гэж хүсэж байна л даа. Гэхдээ хоёрхон сарын дараа үндсэндээ манай энэ гишүүд ер нь хариуцлагын өмнө бол та бүгд маань тийм ээ дэмжээгүй тохиолдолд яг энэ шигээ ингээд тодорхой байгаарай гэдэг асуудлыг бас би бас та бүгдэд хэлье.

Ер нь бол дэмжихгүй байр суурьтай гишүүд ерөнхийдөө бол яг өнөөдөр ингээд энэ Төсвийн байнгын хороонд бол байж байна л даа. Тэгээд тийм учраас ер нь энэ хуулиар олгогдсон эрхийг зөрчсөн, ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлын эсрэг тийм ээ энэ

хуулийн төслийг дэмжихгүй байх ийм, дэмжихгүй байх юм бол та бүгд яг энэ.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд эрх зүйн дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Өнөрболор гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Үгүй ээ одоо юм ярихаараа байна шүү дээ өөрсдийнхөө үзэл бодлыг тулгаад байдгаа боль. Энэ хууль байна шүү дээ энэ хууль нүүрс түлшний юм яриагүй. Энэ хууль хаана аваачиж тэр тоног төхөөрөмжийг байршуулах тухай юм яриагүй. Ерөөсөө Монгол Улсын эрчим хүчний салбарын хүчин чадлыг нэмэгдүүлье. Цахилгаан эрчим хүчний 5мвт-ын станц, дулааны 1,5мвт-аас доошгүй хүчин чадал бүхий дулаан үйлдвэрлэх төвүүдийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд чиглэгдсэн тийм үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН-үүдэд орлогын албан татварт нь хөнгөлөлт эдлүүлье гэсэн ийм л зохицуулалт бүхий хууль байгаа юм. Энэ хуулийг би дэмжиж гаргах ёстой гэж ингэж ойлгож байгаа.

Монгол улс ганц Улаанбаатар биш 330 сумтай, хөдөөгийн өчнөөн тосгонуудтай. Эд нарын бид цахилгаан, дулаан хангамжийн найдвартай байдлыг хангах ёстой. Хөдөө орон нутгийн чинь тавигдаж байгаа дулааны үйлдвэрлэлийн төвүүдийн чинь зуух хамгийн багадаа 1,5мвт, тэгээд л тэрнээс дээш л байгаа. Тэрэндээ л нийцсэн байна. Яг 1,5 гэж хэлээгүй шүү дээ, 1,5-аас дээш гэж хэлж байгаа. 5мвт байна уу, 15мвт байна уу, энийг яах зохицуулах ёстой. Хамгийн гол энэ Өнөрболор гишүүний яриад байгаа зүйл бол Улаанбаатар хотод ийм жижиж оврын зуух тавих юм уу, үгүй юм уу гэдгийг тэр тусгай хууль, тусгай

шийдвэрээрээ зохицуул. Энэ бол улсын хэмжээнд ийм төрлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэж байгаа ААН-үүддээ олгож байгаа хөнгөлөлт. Тэрнээс үүнийг хаана байршуулах, тэр бий болгосон эх үүсвэр нь юугаар ажиллах эд нарыг заасан ийм хуулийн зохицуулалт биш шүү дээ. Би өчигдрөөс хойш ийм л юм ярьж байгаа.

Тийм учраас бид энэ ААНОАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих ёстой. Тэгж байж бид энэ орон нутгийн нийгэм, соёлын байгууллагууд, наад аж ахуй, бизнесийн байгууллагууд, зарим айл өрхүүдийнхээ ая тухтай амьдрах чанартай нөхцөлийг бүрдүүлэхэд энэ их том дэм болно. 15мвт гээд та зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Энэ саналыг хэрвээ дэмжчих юм бол орон нутгуудад 15мвт-ын зуух тавьчаад, илүү гарсан үйлдвэрлэсэн дулаанаа хэнд борлуулах юм бэ? Өнөөдөр ерөөсөө наад сумын төвүүдийн чинь хүчин чадал ерөөсөө л 1,5-аас 4-ийн хооронд л байгаад байгаа шүү дээ мегаватт нь. Бид 2мвт-ын зуух хоёрыг зэрэгцүүлж тавиад л ажиллаж байгаа. Ийм л юм яваад байгаа.

Тийм учраас энэ жоохон амьдралдаа нийцсэн, дам дамаа би энэ жижиг оврын юмыг бол орон нутгууддаа буюу тэр хэрэглэгчдэдээ хүрсэн ийм л юуг нь Засгийн газар бодлогоор оруулж ирж байгаа юм байна л гэж ойлгоод байгаа. Тийм учраас энэ ЭХЯ нь ч байж байна, энэ холбогдох байгууллагууд нь ч байж байна. Энэ ихээхэн хүн ам төвлөрчихсөн суурин газрууд дээрээ өмнө барьж байсан бодлогоосоо буцахгүй байлгүй дээ би тэгж л бодож байгаа шүү дээ. Засгийн газрын 62 хүчингүй болоогүй л байгаа. Нэгэнт хуулийн хүрээн дотор зохицуулалтаа хийсэн 62-оо аваад явах байлгүй. Би тэгж л ойлгож байна шүү дээ.

Г.Тэмүүлэн: Үг хэллээ. Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Батжаргал гишүүний яриад байгаа би энэ Шинэ сэргэлтийн бодлого, ХАА-н бодлого мөн эрчим хүчний эх үүсвэрийг хөдөө орон нутагт бол нэмэгдүүлэх асуудлаар бол ерөөсөө огт бодлогын эсэргүүцэл үзүүлээгүй. Энд тийм ээ энэ бодлогыг дагаад өнөөдөр гуя гэгчээр Улаанбаатар хотод тийм ээ маш их олон нүүрсний яндан зуухнууд орж ирээд байгаа учраас л би энийг эсэргүүцээд байгаа юм гэдгийгээ дахин, дахин хэлээд байна.

Би тэр зарчмын зөрүүтэй санал дээр сая Батжаргал гишүүнтэй бол бас санал нэг байгаа нэг зүйл нь бол хөдөө орон нутагт 1,5 байх нь бол зүйтэй зөв, зөв. Орон нутагт юу Улаанбаатар хотод болохоор өнөөдөр нэн ялангуяа энэ тархмал бүсүүдэд эрчим хүчний хомсдол бол ингээд үнэхээр болчихсон байгаа юм байна лээ. Энэ хомсдолоор өнөөдөр юу шийдэгдэх билээ гэхээр 15мвт-ын тийм ээ ийм хүчин чадал бүхий том дэд өртөөнүүд орж ирж байж, энэ хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг эдэлж байж нүүрсний түүхий нүүрс түлэхгүй, харин бүрэн шаталттай 99,99 хувь тийм ээ, ингээд шүүлтүүртэй ийм дэд өртөөнүүд босгох боломж байгаа юм байна лээ. Тийм учраас өнөөдөр би сая зарчмын зөрүүтэй санал дээрээ ингээд илэрхийлсэн байж байгаа. Хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар. Би зарчмын зөрүүтэй санал дээрээ хэн Тэмүүлэн гишүүнээ нэг юу зүйлийг бас ахиад нэмчихье. Хот, хөдөөгийн ялгамжтай. Сая Батжаргал гишүүний бас энэ хэлсэн зүйл дээрээ. Тэгээд 1,5-ыг 15 болгоод, тэгээд хот, хөдөөгийн ялгамжтай гэдэг байдал талаар зарчмын зөрүүтэй саналаа хураалгах хүсэлтэй байна.

Ер нь бол би бас ингээд л ахиад л юу гэдэг юм энэ Тамгын газрын гишүүдэд бас ахиад л давхар хэлье. Өөрөөр хэлэх юм бол энэ дүгнэлтийг гаргасан хүмүүс өнөөдөр дарга нарын даалгавраар тийм үү, лоббигоор иргэдийнхээ эсрэг ийм улайм цайм үгүй гэж бол хэлж болохгүй. Та нар бол бас энэ өөрөө Үндсэн хуульд

тийм ээ яаж зөрчилдөж байгаа юм? Энийг зөвхөн процессын агуулгаар биш, үндсэндээ Үндсэн хуулийн юуг тийм ээ яагаад Үндсэн хуульд энэ зөрчил үүсэж байгаа юм бэ гэдгийг та нар надаар хэлүүлэлгүй маш сайн мэдэж байгаа. Өнөөдөр энэ агаарын бохирдлоос болоод тийм ээ өчнөөн олон хүмүүсийн өвчний гол шалтгаан болж байна. Энэ 100 мянган хүн тутам ноогдох агаарын бохирдлын шалтгаанаас нас баралтын тоо бол тийм ээ 1,4 дахин их байна манай Монгол дэлхийн дунджаас. Тэгээд бид нар өнөөдөр түүхэн гаргасан намын болоод тухайн үеийн Засгийн газрын шийдвэрийн эсрэг ухарсан бодлого яг адилхан намын гишүүд ингээд гаргах гэж байгаад бол үнэхээр харамсаж байгаа юм.

Тийм учраас гишүүд маань энэ зарчмын зөрүүтэй саналыг тийм ээ ингээд бүрэн дэмжиж өгөөч гэж бол би бас ингээд хүсэж байна. Дээрээс нь гээд тэгэх юм бол ер нь бол Чойжилсүрэн гишүүний хэлээд байгаа, одоо энэ хүмүүс хэлээд байгаа байхгүй юу. Энийг чинь ингээд юу яагаагүй биз дээ, нүүрс гэж заагаагүй байгаа биз дээ, юу гэж заагаагүй байгаа биз дээ. Уул шугамдаа бол заагаад оруулж ирэх ёстой л доо. Энэ чинь өөрөө технологийн судалгаатай. Таныг бол яг ний нуугүй хэлэхэд эрчим хүчний салбарт реформ хийгээч гэж явуулсан болохоос биш аргагүйн эрхэнд нүүрс рүүгээ ухаръя гэдэг ийм бодлогыг баримталж оруулж ирээч гэж томилоогүй байх гэж би бодож байна Засгийн газар. Тийм болохоор чинь улаан цагаан энэ мянган яндан тийм ээ түүхий нүүрс түлэх гээд байгаа энэ зохицуулалтыг би юу яагаач засаач. Хот, хөдөө нь ялгамжтай байдлаар миний зарчмын зөрүүтэй саналыг гишүүд маань дэмжээд өгөөч л гэж та бүгдээс ингээд хүсэж байна. Ийм л хүсэлтэй байна. Баярлалаа. Би зарчмын зөрүүтэй санал дээрээ тэрийг нь юу яачихъя.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Энэ нэг асуудлыг хэдэн ч Байнгын хороо дамжуулж яриу даа. Тэвчээртэй сонсоод байсан асуудал ер нь нэг их сүртэй асуудал биш л дээ. Энэ асуудлыг дэмжсэнээрээ юу гэдэг юм ард түмний дайсан ч болж байх шиг, лоббинд орсон ч болж байх шиг. Үгүй ээ нөхцөл байдал чинь шал өөр шүү дээ. Жишээлбэл энэ чинь өөрөө Өнөрболоор гишүүний яриад байгаа чинь өөрөө эсрэг юм яриад байна шүү дээ. Өнөрболоор гишүүнээ. Яагаад вэ гэхээр энэ чинь орон нутагт сумд мянган янданг нэг болгоё гэж байна, 2 мянган янданг нэг болгоё гэж байна. Өнөөдөр Монгол Улсад цахилгааны бөгөөд дулааны эрчим хүч бүгдээрээ бүх газраа дутагдалтай байж байгаа. Тэгтэл хүсэлт нь 2 дахин, 3 дахин илүү хүсэлт өгчихсөн байж байна. Тэр хүсэлтийг биелүүлэхийн тулд хэдэн 10 жилээр баригдах, хэдэн тэр сая долларын чинь юм нь баригдахгүй байна. Тэр болтол тэгээд өнөөдөр 2 дахин, 3 дахин хүсэлттэй байгаа хүсэлтийг биелүүлж чадахгүй ахиад та 10 жил хүлээ, 20 жил хүлээ гэх юм уу.

Тэгэхээр орон нутагт чинь бүсээрээ байрлалаараа энэ 1,5-тай байрлалууд дулааны станцуудыг чинь барих юм бол харин мянган яндан, 2 мянган яндан, 3 мянган яндан чинь нэг яндан болох гэж байгаа юм биш үү. Тэгээд энийг дэмжсэнээрээ яахаараа эх орныхоо эсрэг болдог юм. Энийг дэмжсэнээрээ яагаад лоббинд орсон болдог юм. Өөрийг нь дэмжихгүй бол бүх хүн дайсан болж байгаа юм уу. 2 талтай шүү дээ энэ чинь. Өөрөө Улаанбаатарыг боддог гэхэд бид нар Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн 21 аймаг тэр 330 гаруй сумыг чинь бас бодож байна шүү дээ. Ямар ойлгомжгүй юм ярьдаг юм. Тэгээд минийх л туйлын үнэн гээд, тэгээд дуугарахгүй болохоор загнаад байх юм.

Тэр намынхаа юмыг нам дээрээ л ярь л даа. Танай намын бодлого хэзээ хэрэгжиж байсан юм ер нь. Хэрэгжсэн юм нь хаана байгаа юм. Тэр нөгөө долларын ханиш. Тэгээд энд ирээд бид нарыг загнаад байдаг нь ямар учиртай

юм. Бүлэг дээрээ ярихад яадаг юм та нар. Ганихан түүхий нүүрс юм уу, тэр долларын хани, үнэ, юмны үнэ, цалин пүнлүү, инфляц гээд. Танай намын ярьж байгаа юм хэрэгжиж байгаа юм юу байгаа юм юу ч байхгүй шүү дээ. Тэгээд одоо нэг энэ уурын зуухыг зохицуулаад мянган янданг нь, 5 мянган янданг нь 1 болгоё, 5 болгоё гээд тэгээд энийг нь бас дотоодын үйлдвэрлэгч нараа дэмжье, татварын хөнгөлөлт үзүүлье гээд тэгээд энийг нь дэмжингүүт дайсан болдог, Монголын дайсан болдог, лобби лоббид автсан болдог. Хэчнээн Байнгын хороо дамжиж сонслоо шүү дээ. Бас хоорондоо маргаад байгаа юм байна, учраа олчих гэж байна.

Тэгээд Тамгын газраа юунд лоббинд автчихсан гэж байна, авлигад автчихсан гэж байна. Яагаад бас энэ бид нарыг хүндэлдэггүй юм. Хэдэн удаа хойшлов энэ одоо. Энийгээ бүлэг дээрээ ярихад яадаг юм та нар. Тийм л намын бодлогын асуудал юм бол. Төрийн бодлого ярьж байгаа бол ингэж завхруулдаг боль. Намын бодлого ярьж байгаа бол бүлэг дээрээ шийдчихээд гараа өргөчхөөд орж иржээ та нар. Тэгээд энд орж ирээд өөрсдийнхөө тэр асуудлыг бид нартай нийлүүлж загнадгаа боль. Та нарт загнуулах гээд энд суугаа ч үгүй ер нь. Яахаараа бид нар нийгмийн дайсан байж байдаг юм, яахаараа бид нар лоббичин байж байдаг юм. Бид нар нутаг орноо асуудлыг шийдье, дулааны эрчим хүчээр хангая гэж байна. Тэр хангах нөхцөлийг нь бүрдүүлэх тэр татварыг нь хөнгөлөөд өгье л гэж байна. Тэрийг дэмжсэнээрээ яахлаараа дайсан болж байдаг юм. Тэр загнах юмаа тэр бүлэг дээрээ загнаж бай. Энд ирж бид нарыг загнах гэх юм бол ярина шүү та нартай. Ер нь амар юм болж байх юм.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүн санал хэллээ. Өнөрболор гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна. Саналын томъёолол нь ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.5мвт-аас

гэснийг 15мвт-аас гэж өөрчлөх /хот хөдөөгийн ялгамжтай/ гэсэн байдлаар саналаа өгсөн байгаа. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 42.2 дээр холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно гэсэн байгаа.

Энэ бол 42.2.1-ээр нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, заалт, хэсэгтэй хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд ишлжүүлсэн тохиолдолд гэж байгаа юм нэгдүгээрх нь. Хоёрдугаарх нь бол 42.2.2-оор анхны хэлэлцүүлгээр дэмжсэн зарчмын зөрүүтэй санал нь өөр хоорондоо эсвэл бусад хуультай зөрчсөн талаарх энэ хуулийн 38.2-т заасан эрх зүйн дүгнэлтийг ХЗБХ дэмжиж санал, дүгнэлт гаргасан гэдэг. Нөгөөх нь бол 42.2.3 нь нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. 42-ын, 42.3 дээр бас энэ хуулийн 42.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийг дэмжсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал хураалт гаргахыг хориглоно гэсэн ийм дэгийн заалттай юм байна. Тэгээд энэ асуудлыг бас Өнөрболор гишүүн та ойлгож үзээрэй.

Ингээд эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Батсуурь гишүүн та чуулган танилцуулах уу? Батсуурь гишүүн чуулганд танилцуулъя. Ингээд хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Гурав. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

3 дахь асуудалдаа оръё. Хууль баталсантай холбогдуулах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Хууль тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол гаргаж болно гэж заасан байгаа. Энэ дагуу тогтоолын төслийг боловсруулсан. Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. 1 дүгээрт. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын ... тэдний өдөр баталсантай холбогдуулан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын

Засгийн газарт даалгасугай гээд. Нэг нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварыг хэсэгчлэн төлөх хугацааг сунгах асуудлыг бусад хуультай нийцүүлэн судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн байгаа.

Хоёрт Монгол Улсын Их Хурал 2020 онд баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын 6.4-д заасан нүүрс төрөгч багатай хүртээмжтэй, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил зорилтын хүрээнд дулааны болон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж буй түүхий эдийн стандартыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн зөрүүг тэглэх ажлыг эрчимжүүлэх. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоол байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Чойжилсүрэнгээр тасаллаа. Чойжилсүрэн гишүүн.

Б. Чойжилсүрэн: Тэмүүлэн даргаа, энэ 2 зүйлтэй юу тогтоол юм байна тийм ээ. 2 дугаар зүйлд нь жишээлбэл хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн хэмжээгээрээ Монгол Улс шингээлт нь өндөр байгаа. Бусад улс орнуудтай харьцуулахаар. Тэгэхээр бид нар гаднын юу хөрөнгө юу хүмүүстэй уулзахаараа ярьж байгаа. Хөгжингүй орнууд та нар бид нараас санхүүгийн бололцоотой мөртөө бид нар шиг юу шингээлттэй бол л доо. Тэгэхээр бид нар энэ өөрсдөө тэглэнэ гэдэг бодлого ингэхээр та нар ямар асуудал гарах бол. Энийг өөрчлөн найруулах бололцоо бий юу. Манай улсын хувьд бол шингээлт нь юу ялгаруулалтаасаа өндөр байгаа шүү дээ. Яг урд тал, урд талын

хөрш, бусад улс орнууд дээр бол ялгаруулалт нь өндөр байгаа.

2 дугаарт энэ нөгөө Тэмүүлэн дарга энд ингээж ойлгосон нь зөв үү? Татварын 1 дүгээр зүйл нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварыг хэсэгчлэн төлөх хугацааг сунгах асуудлыг бусад хуультай нийцүүлэн судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барь гэдэг нь одоо байгаа 29 оны 12 сарын 31 хүртэл энэ юу үзүүлж байгаа хөнгөлөлтийг цаашид тогтворжуулчих вий гэсэн ийм болгоомжлол гэж ойлгосон зөв үү? Тэр 2 дугаар заалт дээр найруулах шаардлага байна уу? Тэгэхгүй нөгөө гаднынхан чинь та нар нуусан юм байна гээд л яг эхэлнэ шүү дээ.

Г.Тэмүүлэн: Окэй, ойлголоо. 2 дахь заалт дээр гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Та тэгээд томъёоллыг нь бичээд үг, үсэг дээр найруулга өөрчлөх барих зүйл бол гялс бичээд өгөөдхөөрэй.

Нэг дэх асуудал дээр нь ийм зүйл байгаад байгаа юм. Бид нарын хувьд болгоомжилж байгаа зүйл нь бол 2029 оны 12 сарын 31 хүртэл энэ хууль үргэлжилнэ. Үүнээс цаашаа тогтвортой байдлын гэрээтэй, хөрөнгө оруулалтын гэрээтэй ААН-үүд байгууллагууд тухайн тэр татвар болоод татварын хувь хэмжээний тогтворжуулалтыг үргэлжлүүлээд явах эрсдэл байна гэсэн үндсэн дээр тэр татвар, Татварын хууль байна уу, Хөрөнгө оруулалтын тухай хууль байна уу тэр хуулиуд дээр нь энэ асуудлуудыг нягталж, тухайн тэр юу гэдэг юм цаашид тогтворжуулалтын тэр эрсдэлийг хаах гэдэг юм уу, яг 29 оны 12 сарын 31-ээрээ дуусгавар болох энэ зохицуулалтыг бол та бүхэн бас хууль зүйн талаас нь нийцүүлж оруулж ирээрэй гэдэг асуудлыг бол тусгаж оруулж ирж байгаа юм. Тэгэхээр бол Чойжилсүрэн сайд таны хэлсэн 29 оны 12 сарын 31-нээс цаашаа тогтворжих тэр тогтворжуулалт үргэлжлээд явах эрсдэл байгаад байгаа учраас тэрийг

хаах эрх зүйн зохицуулалтыг бол оруулж ирье гэсэн ийм чиглэл болгосон заалт байгаад байгаа юм.

2 дахь заалт дээр та томъёолол болоод үг, үсгийн найруулгын өөрчлөлт заалт байвал тэрийг би таны саналыг уншаад танилцуулаад, тэгээд санал хураалгачихъя. Өөр тодруулах зүйл байгаа юу юу? Чойжилсүрэн гишүүний гаргасан 2 дахь санал дээр гаргасан зарчмын зөрүүтэй санал нь Монгол Улсын Их Хурал 2020 онд баталсан Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын 6.4-т заасан нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил зорилтын хүрээнд дулааны болон цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж буй түүхий эдийн стандартыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэж байгаа юм байна. Энэ томъёоллоор санал хураалт. Чойжилсүрэн гишүүн ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Та горимын санал гаргах уу? Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Даалгасугай, хуультай нийцүүлэн судалж холбогдох хууль тогтоомж боловсруулан хуульд өргөн мэдүүлэх. Нөгөө бодлого төлөвлөгөөгөө яг, Их хурлын, нүүрс төрөгч. Энэ дээр би саяынхаа тэр энэ хуулийн 2 дээр нь, 2 дээр нь тийм төслийн 2 дээр, төслийн 2 дээр байна шүү дээ тийм ээ 1.2 дээр юу оруулмаар байна. Тийм энэ 1.2 дээр нөгөө саяынхаа саналыг оруулмаар байна. 1,5-ыг 15мвт болгож тэгээд хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар гэдэг ийм агуулгыг энэ дотор оруулъя. Хот, хөдөөгийн ялгамжтай гэдэг байдлаар гэж хэлээд байна Батсуурь гишүүнээ. Та технологио судлаад ярья. Тийм тогтоол дээрээ тэгж оруулъя.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн горимын зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаж байна. Чойжилсүрэн

гишүүн гаргасан. Өнөрболор гишүүний, Өнөрболор гишүүний тогтоолын төслийн 1.2 дээр гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор эхлээд санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 16,7 хувиар дэмжигдсэнгүй. Дэмжээгүй учир Чойжилсүрэн гишүүний саналаар гаргасан 1.2 дээр гаргасан томъёоллыг түрүүн уншиж танилцуулсан. Чойжилсүрэн гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалтыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Ингээд ингээд Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны гарах санал, дүгнэлтийг Баделхан дарга та танилцуулчих уу? Баделхан гишүүн танилцуулъя. Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

13.55 цаг

Дөрөв.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа орцгооё. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлъя. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хууль, тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын

Их Хурлын гишүүн Пүрэвдорж гишүүнээр танилцуулъя. Пүрэвдорж гишүүн. Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

13.56 цаг

Тав.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /эцсийн хэлэлцүүлэг/

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлъя. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд бэлтгэн тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авчирч дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүн танилцуулъя.

13.57 цаг

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА